

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр, Лхагва гараг

| | |
|--|------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга | 1 |
| Хуралдааны товч тэмдэглэл: | 2-3 |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 4-23 |

| | |
|---|------|
| 1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам батлах тухай/ | 4-23 |
|---|------|

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан;
Чөлөөтэй: Ж.Батсуурь, Б.Жавхлан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Журмын төслийн талаар ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Х.Баасанжаргал, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Байнгын хорооны дарга Б.Баярбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Ч.Лодойсамбуу, Х.Баасанжаргал, Г.Очирбат нар үг хэлэв.

“Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Баярбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 2.2 дээр “48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 6
Бүгд: 9
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 2.3 дахь заалт болгож “хуралдаан зохион байгуулагч бусад гишүүдэд гишүүн оролцох эсэх талаар мэдээллийг 24 цагаас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ.” гэж шинээр заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 7
Бүгд: 9
22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 2.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 8
Бүгд: 9
11.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнг дэмжсэнээр тооцож, 22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зарчмын зөрүүтэй санаын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу тогтоолын төслийг дахин хэлэлцэх шаардлагатай тул хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 6
Бүгд: 9
33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу үг хэлэв.

Б.Баярбаатар: “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 11 цаг 11 минут.

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Баярбаатар: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны хамгийн эхний буюу 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны ирц хүрсэн тул ирцийг та бүхэнд танилцуулж хурлыг нээе. Баярмагнай овогтой Баярбаатар ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь гишүүн Засгийн газрын хуралдаанд байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна. Болдын Жавхлан гишүүн Засгийн хуралдаанд байгаа, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн орон нутагт томилолттой, Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирцдээ орчихсон юм уу? Ирсэн байна. Ингээд ирц хүрсэн учраас өнөөдрийн хурлыг нээснийг мэдэгдье ээ.

Нэг асуудал хэлэлцэнэ. Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны хамрах асуудлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллаж байгаа тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд оролцох журмыг батлах үүргийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хүлээдэг. Энэ дагуу өнгөрсөн хуралдаанууд дээр Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүн Аюушийн Ариунзаяа гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг гаргаж ажиллуулсан. Ажлын хэсэг ажиллаж журмын төслийг боловсруулж Улсын Их Хурлын Тамгын газар болон Монгол Улсын ЗГХЭГ холбогдох салбарын сайдуудаас нь саналыг авч нэгтгэснээр өнөөдөр ингээд Ёс зүй, дэгийн байнгын хорооныхоо хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

Энэ журам бол эцсийн байдлаар манай Байнгын хорооноос батлагдаж гарна. Цаашлаад ямар нэгэн байдлаар Засгийн газар буюу Улсын Их Хурлын шатад дахиж хэлэлцэгдэхгүй. Тийм учраас нэлээн хариуцлагатай ийм журам байх ёстой. Дээр нь анхааруулж буюу сануулж хэлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагынхан энэ журмыг нэлээдгүй сонирхоод эхэлсэн байна.

Тэгэхээр энэ журмын танилцуулгыг Ариунзаяа гишүүн та их сайхан дэлгэрэнгүй хийгээд манай Байнгын хороодын гишүүд маань дараа нь хэвлэл мэдээллийн байгууллагад энэ талаараа мэдээлэл өгөхөд зөв болов уу гэсэн үүднээс танилцуулгыг нэлээн дэлгэрэнгүй хийгээрэй гэж хүсэж байна аа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүн Ариунзаяа гишүүнийг танилцуулгаа хийхийг хүсье.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дарга эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе за. Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх Улсын Их Хурлын гишүүний Улсын Их Хурлын чуулганы ажиллагаанд оролцох журмыг Улсын Их Хурлын тухай хуулиар, журмаар зохицуулах үүрэг даалгаврыг Ёс

зүй, дэгийн байнгын хороонд өгсөн байдаг. Үүний дагуу Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.6 дахь заалтад заасан Ёс зүй, дэгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 3 дугаар тогтоолоор баталсан байдаг. Ингэхдээ надаар ахлуулж Аюушийн Ариунзаяа ахлан ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн давхар сайдаар ажиллаж байгаа 2 хүн орсон. Батсуурь, Жавхлан. Мөн түүнчлэн Очирбат, Энхтуяа нарын гишүүд багтсан ийм ажлын хэсэг 2 сарын хугацаанд ажиллалаа. Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Наранцэцэг, Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Бямбадулам, нарийн бичгийн даргаар Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны референт Мөнгөнчавхдас мөн ажилласан.

Энэ хугацаандаа бол Засгийн газартай болон Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн хэлтэс болон бусад мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажилласан. Мэдээж манай ажлын хэсгийн үүрэг даалгавар нь бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдахгүйгээр гэхдээ энэ ёс зүйн болон дэгийн зөв зохистой байдлыг хангах маш товч тодорхой жижиг энэ журмыг боловсруулах үүрэг даалгавартай байсан. Монгол Улсын Их Хурлын тухай 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт гишүүн Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнээр томилогдсон бол түүний чуулганы ажиллагаанд оролцох журмыг Ерөнхий сайдын саналыг харгалзан Ёс зүй, дэгийн байнгын хорооны тогтоолоор батална гэж заасан.

Ерөнхий сайдын санал гэдэг маань өөрөө кабинетын санал учраас сайд нар тухайлж саналаа өгсөн болно. Засгийн газраас санал авахаар 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр албан тоот явуулж 1 сарын хугацаанд Засгийн газар дээр хэлэлцүүлэн Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр саналаа ирүүлсэн. Ажлын хэсэг бол саналыг нэгтгэн төслийг боловсруулж журмын төслөө бол та бүхэнд оны өмнө мөн тараасан байгаа учраас та бүхнийг танилцсан байх гэдэгт бол итгэлтэй байна аа.

Хамгийн гол онцлох зүйл заалтууд нь ерөнхийдөө юу юм бэ гэхлээр журмын төсөл 3 хэсэгтэй, 12 заалттай бөгөөд журмаар зохицуулж байгаа зүйл заалтуудыг товчхон илэрхийлэхэд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д заасны дагуу гишүүн өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаад томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, Дэд болон Түр хорооны хуралдаанд товлосон хугацаандаа оролцох үүрэгтэй. Тухайн 7 хоногт нэгдсэн, байнгын, дэд, түр хороо, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дарааллын баримтлан бусад хуралдааныг аль болох давхцуулахгүй байхаар төлөвлөх ийм үүргийг мөн хүлээж байгаа. Хүндэтгэн үзэх шалтгаанаар нэгдсэн, Байнгын, Дэд, Түр хороо ажлын хэсгийн хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэнэ гэсэн ийм зүйл заалт байдаг учраас үүнийг ч гэсэн яг адил хэдийгээр Засгийн газрын гишүүн маш их ажилтай ч гэсэн ажлаа төлөвлөж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг хүндэтгэн үзэж ажлаа тэр байдлаар төлөвлөнө. Давхардуулан ямар нэгэн байдлаар хуралдаануудыг зохион байгуулахгүй нэн шаардлагатай гэж үзэх юм бол урьдчилан мэдэгдэж чөлөө авна гэдгийг бол журамд тогт тусгайлж заасан.

Хоёр дахь нь болохлоор Засгийн газар нь асуудлын хамтдаа хэлэлцэж байгаа учраас ер нь кабинетын зарчмыг мөрддөг Засгийн газрын тухай хуулиараа ч гэсэн заагаад өгсөн байгаа. Тэгэхээр яг кабинет дотроо сайд нар мэтгэлцэж өөр

өөрсдийнхөө байр суурийг илэрхийлж эсрэг сөрөг саналтай байсан ч гэсэн хамтын шийдвэр гаргаад явсан бол хамтын нэгдсэн дуу хоолойтой байх ёстой гэдэг ийм зарчим бол Засгийн газрын тухай хуулиараа бол байдаг. Засгийн газрын тухай хуулийн ийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн олонхын саналаар шийдвэрлэсэн хуулийн төсөл болон төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлын чуулган дээр мөн түүнчлэн Байнгын хорооны хуралдаан дээр Засгийн газрын гишүүний хувьд зарчмын өөр санал илэрхийлэхгүй гэж заасан байдаг аа. Энэ нь бол кабинетын зарчим гэсэн үг.

Энэ агуулгаараа Улсын Их Хурлын чуулганаар Засгийн газраас өргөн барьсан аливаа хууль тогтоомж, бодлого дээр Засгийн газрын гишүүн өөрөө ямар нэгэн байдлаар эсрэг санал илэрхийлэхгүй. Нөгөө талдаа асуулт асуухгүй буюу өөрөө тухайн асуудлыг оруулж ирж байгаа субъект учраас өөрөө өөрөөсөө асуулт асуухгүй гэдгийг бол Улсын Их Хурлын чуулганы индэр дээрээс Улсын Их Хурлын дарга тухайн асуулт асуухаар нэрсээ өгөх явцад Засгийн газрын гишүүн асуухгүй гэж илэрхийлж нэрийг нь хасуулдаг бол үүнийг журамдаа зохицуулж өгч журмаар оруулж ирж байна гэж ойлгох ёстой.

Засгийн газрын гишүүн бол асуултад хариулж болно, үг хэлж болно, дэмжсэн байр сууриар үг хэлж болно гэдгийг бол тухайлж энэ журмаар зохицуулсан гэсэн үг. Хэрэвзээ Засгийн газраас санаачилж оруулж ирсэн хуулийн төсөл дээр зарчмын зөрүүтэй тухайн үедээ мартагдсан ч юм уу үнэхээрийн зарчмын зөрүүтэй санал гаргахаар бол түүнийг тухайн асуудлыг эрхэлж байгаа сайд нь гаргана. Эс үгүй бол тухайн Ерөнхийлөгчтэй, Улсын Их Хуралтай харьцдаг эрх бүхий сайдаар дамжуулж гаргаж болно гэсэн ийм зүйл заалт зохицуулалтыг бол оруулж өгсөн.

Нөгөө талдаа бидний хараад байгаа жишээлбэл төсвийн хэлэлцүүлгийн явцад ямар нэгэн байдлаар чуулганы хуралдаанд оролцохдоо сайд биш би Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна гэдэг асуудлыг гаргаад байдаг. Тэгэхээр энэ бол өөрөө ёс зүйн хувьд бол буруу юм гэдгийг энэ журмаар зохицуулж ямар нэгэн байдлаар тухайн сайд Засгийн газраас оруулж ирж байгаа асуудал дээр зарчмын зөрүүтэй санал гаргахгүй гэдэг асуудлыг зохицуулж өгч байна гэсэн үг.

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэгдсэн, Байнгын, Дэд, Түр хороо ажлын хэсгийн хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолоор баталсан Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10.7-д заасны дагуу манай Байнгын хороогоор бас шийдвэрлэх тухайн шатны хариуцлагыг, сануулгыг өгөх мөн шаардлагатай гэж үзэх юм бол Монгол Улсын Ерөнхий сайдад мөн олгогдсон бүрэн эрхийнх нь дагуу тухайн сайдад хариуцлага тооцох саналыг хүргүүлэх талаар энэхүү журамд зохицуулж оруулж ирсэн болно оо гэдгийг бол онцлон хэлье.

Хамгийн гол нь яах вэ мэдээж Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх гэж байгаа боловчиг нэгэнтээ та Засгийн газрын гишүүний үүргийг албан хавсарч гүйцэтгэж байгаа бол эрхийг нь эдэлж байгаа бол ямбыг нь ч гэсэн эдэлье. Нөгөө талдаа бол хариуцлагаа ч гэсэн хүлээх ёстой гэдэг агуулгаар чуулган дээр нэг сайдынхаа малгайг өмсөөд нөгөө талдаа гишүүнийхээ малгайг сольж өмсөөд байх нь ёс зүйн хувьд бол буруу юм аа. Та сайдынхаа хувьд нэгдсэн энэ зарчмаа нэгдсэн

дуу хоолойтой байх ёстой гэдэг зарчмыг журамлаж өгч байгаа хамгийн гол онцлог юм гэдгийг хэлье ээ.

Ерөнхийд нь бол танилцуулж дууслаа.

Журмын хэрэгжилтэд бол манай Ёс зүй, дэгийн байнгын хороо тавина. Бусад Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, гишүүдийн ёс зүйн дүрмийг бол мөн адил мөрдөхөөр байгаа учраас төдийлөн заалтуудыг давхцуулж оруулаагүй болно гэдгийг хэлье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хэлэлцэн баталж өгөхийг хүсье.

Б.Баярбаатар: Аюушийн Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Журмын төслөөс төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Баасанжаргал, Рэгдэл, Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Хэрлэн гишүүн нэмэгдлээ. Баасанжаргал гишүүн ирцээрээ Лодойсамбуу гишүүнээр эхэлнэ.

Ч.Лодойсамбуу: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе ээ.

Байнгын хорооны тогтоолоор Их Хурлын үйл ажиллагаа Их Хурлын гишүүдийн чуулганы хуралдааны үйл ажилд оролцох журмыг батлах гэж байна. Энэ нь Үндсэн хуулийн зөрчил рүү орохгүй юу? Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дээр Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж байгаа, нэгт.

Хоёрдугаарт чуулганы хуралдаанд оролцоод энэ гол зохицуулалт нь Засгийн газрынхаа танхимынхаа эсрэг Засгийн газрынхаа байр суурийн эсрэг үг хэлж болохгүй. Ер нь үг хэлж асуулт асууж болохгүй гээд энийг л зохицуулах гэж байгаа журам гэж ойлгож байгаа. Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн нэг дээр Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална аа. Одоо бид нар нэг 20 гишүүний асуудлыг ярьж байна шүү дээ. Засгийн газрын 20 сайд, 20 гишүүн. 20 гишүүний бүрэн эрхийн асуудал. Энэ сонгогдсон тойргийнхоо тухайн газар нутаг бүс нутгийнхаа элч төлөөлөгчийн элч төлөөлөгч нарын асуудлыг ярьж байгаа. Эд нар бүгдээрээ тангараг өргөчихсөн.

Тэгэхээр Үндсэн хуулийн ийм 2 заалттай шууд зөрчилдөөд байгаа. Дээр нь энэ дээр Засгийн газраас ч гэсэн ирүүлсэн санал дээр нь байж байгаа. Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.8-д хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн дагуу асуулт асуух, байр сууриа илэрхийлэх, санал гаргах, санал хураалгах эрхтэй. Хэдийгээр Засгийн газрын гишүүн ч гэсэн энэ бол олон нийтээс сонгогдсон мандат авч орж ирсэн Улсын Их Хурлын гишүүн.

Тэгэхээр гишүүний бүрэн эрхэд энэ шууд халдаж байгаа нөхцөл байдал үүсэж байна гэж Засгийн газрын энэ мэдээлэл дээр ч гэсэн өгсөн байна. Дээр нь энэ журам дээр хуулиар тэртээ тэргүй зохицуулчихсан байгаа зүйлүүдийг оруулж ирсэн байна лээ. Жишээлбэл журмын 2.7, Улсын Их Хурлаар төсвийн хүрээний мэдэгдэл улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг хэлэлцэхэд гишүүн чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад

тохиолдолд оролцох үүрэгтэй гэж энэ Их Хурлын дэгийн дэгийн тухай хууль дээр байж байгаа.

Тэгэхээр хуулиар нэгэнт зохицуулсан зүйлийг тогтоолоор журам батлаад ингэж оруулж ирэх нь хэр зөв бэ? Одоо манай Байнгын хороо жишээлбэл Үндсэн хуулиа зөрчөөд нэг журам баталчих юм биш биз дээ гэдэг нэг ийм асуулт байна.

Б.Баярбаатар: Ажлын хэсэг хариулах уу? Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Яах вэ ер нь бол таны хэлж байгаа асуудлууд бол зөв л дөө. Бид хуулийнхаа хүрээнд л ажил үүргээ явуулах ёстой. Ямар нэгэн байдлаар Ёс зүй, дэгийн байнгын хорооноос хуулиа даваад ажлын хэсэг байгуулаад үүрэг даалгавар албажуулаад, үүрэг даалгавар авсан ажлын хэсэг нь хууль зөрчөөд ямар нэгэн байдлаар журам боловсруулаад ирсэн асуудал байхгүй ээ. Хуулиар Монгол Улсын Их Хурлын тухай хууль дээр байгаа асуудал. Гишүүн 43 дугаар зүйлийн 43.3 дээр байгаа гишүүн хавсран гүйцэтгэж болох ажил албан тушаал заасан энэхүү зүйл дээр 43.3-д гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдсон бол түүний чуулганы ажиллагаанд оролцох журмыг Ерөнхий сайдын саналыг харгалзан Ёс зүй, дэгийн байнгын хорооны тогтоолоор батална гэдгийг бол заагаад өгсөн байгаа. Ер нь бол алсдаа журмаар биш энэхүү хуульдаа оруулаад явах юм бол илүү зөв зохистой болно гэдэг нь бол зүйтэй. Энийг Улсын Их Хурлын тухай хууль байна уу, Улсын Их Хурлын Дэгийн тухай хууль байна уу дараагийн томоохон энэ өөрчлөлтийг хийхдээ аль болох журмаар биш харин хуулиараа зохицуулах нь бол өөрөө зүйтэй юм аа.

Яагаад Улсын Их Хурлын гишүүн давхар сайдаар ажиллах боломжтой мөртөөсөө эргүүлээд эрхийг нь Улсын Их Хурлын гишүүнээр нь олгогдсон эрхийг нь хязгаарлах гээд байгаа юм бэ гэхээр дахиад л нөгөө нэг хуулиар зохицуулагдсан буюу Засгийн газрын тухай хуульд байгаа зүйл заалтаараа зохицуулагдсан байгаа юм аа. Засгийн газрын тухай хууль дээр юу байгаа вэ гэхээр тухайн Засгийн газрын хуралдаанаар 24 дүгээр зүйлийн Засгийн газрын гишүүний бүрэн эрх дээр заагаад өгсөн 5 дугаар зүйл дээр нь 24 дүгээр зүйлийн 5 дээр Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн олонхын саналаар шийдвэрлэсэн хуулийн төсөл төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаан Засгийн газрын гишүүний хувьд зарчмын өөр санал илэрхийлэхгүй гэдэг ийм асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр Засгийн газар нь тухайн Засгийн газраас оруулж ирж байгаа хуулийн төслөө хэлэлцэхдээ сайд нар тухайлж танилцах хугацаатай, тухайн мэргэжлийн газруудаараа саналаа боловсруулаад бичгээр, албан тоотоор өгөөд, хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналуудаараа саналаа хураагаад нэгдсэн 1 бодлогоо оруулж ирдэг учраас үүн дээр хэлэлцсэн хойноо чуулган дээр орж ирчхээд би сайдынхаа хувьд биш би гишүүнийхээ хувьд гэж өөр малгайгаа өмсөөд тэ нэг дээлээ тайлангуутаа нөгөө дээлтэйгээ суугаад яриад байж болохгүй нь гэдэг л ийм ёс зүйн хувьд буруу юм гэдгийг Ёс зүй, дэгийн байнгын хорооноос энэхүү асуудлыг хуулийнхаа дагуу зохицуулж өгч байгаа юм гэсэн үг.

Ер нь бол бусад бүхий л хуулиуд дээр бол энэ асуудал биш шүү дээ. Зөвхөн Засгийн газрын өөрийн боловсруулж оруулж ирж байгаа хууль тогтоомж дээр л ярьж байгаа. Тэрнээс биш бусад субъект бусад Улсын Их Хурлын гишүүд оруулж ирсэн хууль дээр асуулт асуух нээлттэй, үгээ хэлэх нээлттэй хууль санаачлах эрх нь ч гэсэн нээлттэй байгаа шүү дээ. Тухайн Засгийн газрын гишүүд хүртэл Засгийн

газраараа биш хувь гишүүнийхээ хувьд хууль боловсруулж оруулж ирж байгаа ийм явдлууд ч гэсэн тохиолдлууд гарч эхэлж байгаа учраас энэ агуулгаараа бол ямар ч хуулийн зөрчил үүсэхгүй гэж бодож байна аа.

Хэрэвзээ Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзэхээр байгаа бол эдгээр хуулиуд батлагдаж байх үед тэр нь бол яригдах байсан. Тэгэхээр эдгээр хуулиуд Үндсэн хууль зөрчөөгүй учраас манай энэ журам ч гэсэн Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна аа. Баярлалаа.

Б.Баярбаатар: Лодойсамбуу гишүүн тодруулна.

Ч.Лодойсамбуу: Үндсэн хуулийн зөрчилтэй Монголд нэг яг Байнгын хэрэглэгдэж байгаа 800 гаруй хууль байгаа. Үндсэн хуулийн зөрчилтэй тэрний нэг 60 орчим хувь нь зөрчилтэй байна гээд манай Их Хурлын дарга өөрөө хүртэл зарлаад байгаа. Тэгэхээр байгаа хуулиуд нь Үндсэн хуулийн зөрчилгүй гэж шууд хэлэх нь бол өрөөсгөл юм. Асуулт нь Монгол Улсад Монгол Улсын Үндсэн хууль нь том юм уу, Засгийн газрын тухай хууль, Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль нь том юм уу? Ёс зүй, дэгийн байнгын хороо Үндсэн хуулиа дээдэлж ажиллах юм уу? Бусад хуулиудаа мөрдөж ажиллах юм уу?

Тэгэхээр бид нар яг энэ Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг ил би хуульч биш. Гэхдээ ингээд харахад бол зохион байгуулалт үйл ажиллагаанд оролцож байгаа дээр нь энэ ард түмний нийтлэг эрх ашиг элч төлөөлөгч мөн гэдэг энэ заалтуудыг зөрчсөн асуудлыг л ярилцаад сууж байгаа юм. Тэгэхээр энэ аль нь том юм бэ? Монголд? Үндсэн хууль нь том юм уу? Бусад хуулиуд нь том юм уу?

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Нэгэнтээ ийм асуулт асууж байгаа юм чинь хариулах үүргийг би хүлээж байгаа байлгүй. Ажлын хэсгийн даргын хувьд. Гагцхүү Үндсэн хууль том юм уу бусад хууль том юм уу гэдэг нь өөрөө өрөөсгөл асуулт болов уу даа. Яагаад гэвэл хууль бол хууль. Ямар ч хууль байсан бай мөрдөгдөх ёстой. Гагцхүү та бид 2 Үндсэн хууль зөрчсөн байна уу, үгүй юү гэдгийг тогтоодог субъектүүд бол биш тиймээ. Тэгэхээр яг одоо байгаа бидний өмнө байгаа энэ хууль тогтоомжийнхоо хүрээнд, үүрэг даалгаврынхаа хүрээнд боловсруулагдаж орж ирж байгаа журам учраас ямар нэгэн байдлаар мөрдөгдөж байгаа хууль болоод зөрчсөн эсэхийг үл тогтоосон ямар нэгэн тийм тогтоол байхгүй байгаад байна шүү дээ. Засгийн газрын тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа учраас тэдгээрийнхээ дагуу энэхүү журам орж ирж байгаа учраас ямар нэгэн хуулийн зөрчилгүй гэж үзэж байна аа.

Хэрэвзээ ямар нэгэн байдлаар зөрчсөн гэдэг өргөдөл гарах юм бол тухайн хууль зөрчсөн эсэхийг тогтоох субъект нь өөрөө хүлээсэн үүргийнхээ дагуу тухайн шийдвэрийг гаргана.

Б.Баярбаатар: Ер нь бол ийм. Үндсэн хуулийг зөрчсөн эс зөрчсөн болон аливаа хуулийг тайлбарлах эрх бидэнд байхгүй. Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороодын хамрах асуудлын хүрээг зааж өгсөн байгаа. Тэр хүрээнд өнөөдөр энэ асуудлыг Байнгын хороо санаачлаад хэлэлцээд үүргээ биелүүлээд явж байгаа гэж ойлгож болно, нэгт.

Хоёрт өнөөдөр Засгийн газрын гишүүнийг хавсран гүйцэтгэж байгаа Улсын Их Хурлын гишүүн ард түмний төлөөлөл мөн үү гэвэл мөн. Тэгэхдээ өнөөдөр кабинетын шугамаар ажилладаг Засгийн газар бол ард түмний төлөөлөл биш. Тэр бол гүйцэтгэх байгууллага. Тэр зарчмаараа тэр хүн өнөөдөр Засгийн газарт ороод Засгийн газрын гишүүний үүргийг хүлээгээд ажиллаж байгаа тохиолдолд кабинетын зарчмаар нэгдсэн шийдвэрийг гаргаад оруулж ирж байгаа тохиолдолд Засгийн газрын оруулж ирсэн шийдвэр дээрээ Улсын Их Хурал дээр эсрэг байр суурь илэрхийлэхгүй байх нь өөрөө зарчмын том соёл. Энийг төлөвшүүлэх ёстой өмнө нь энэ болж байсан процесс л доо. Гарч ирээд шууд хэвлэлд ч тэр, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд ч тэр Засгийн газрынхаа эсрэг байр суурийг илэрхийлээд ярьж байгаа юм. Тэгээд энэ болгоны цаана хүн үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хуулиар нээлттэй байж болно.

Тэгэхдээ өнөөдөр төрийн ажил тасралтгүй явах, дээр нь өөрөө энэ эв нэгдэл, үндэсний эв нэгдэл. Энэ мэдээж тэр байр сууриа янз бүрийн шатан дээрээ Засгийн газрын хуралдаан дээр бусад өмнөх шатын хуралдаанууд дээр илэрхийлж болно. Гагцхүү Засгийн газраас оруулж ирж байгаа аливаа асуудлын төсөл дээр энэ байр сууриа Засгийн газар дээрээ илүү сайн ярилцаад дараа дараагийн Байнгын хороо нэгдсэн чуулган дээр энэ асуудал нь яригдахгүй байх нь зөв болов уу гэсэн ийм журмын гол концепц байна. Би бол тэгж ойлгож байна, нэгт.

Хоёрт энэ хуулийн зөрчилтэй гэж үзэх юм бол жишээлбэл Байнгын хорооны гишүүдэд Засгийн газрын гишүүн тухайн харьяалсан салбар Байнгын хороондоо орохгүй гэдэг асуудал чинь өөрөө хуулийн зөрчил рүү татна. Хэрвээ татагдвал жишээлбэл Сангийн сайд Төсвийн байнгын хороонд орж болохгүй ээ. Нэг талаасаа ашиг сонирхол, нөгөө талаасаа тэр чинь Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал байхгүй. Яг нарийн том одоо ингээд хөтлөөд гэх юм уу, ардаас нь хөөгөөд явах юм бол энэ ч гэсэн өөрөө хуулийн зөрчил рүү татагдах магадлалтай л асуудал байхгүй юу. Магадлалтай. Тэгэхээрээ энэ Лодойсамбуу гишүүний хэлж байгаа зөв. Хэрвээ Үндсэн хуулийн зөрчилтэй гэдэг асуудал гараад ирэх юм тэр манай Байнгын хорооны асуудал биш Их Хурлын тухай хуулийн асуудал орж ирэх юм байгаа юм. Тэр хууль хэзээ ямар процессыг давж батлагдаад өнөөдөр хэрхэн мөрдөгдөж байгааг манай гишүүд өөрсдөө бүгд мэдэж байгаа учраас бид нар хуулиар олгогдсон үүргийг хүлээгээд өнөөдрийн журмыг ажлын хэсэг байгуулаад оруулж ирж байгаа шүү гэдгийг нэмэлтээр хэлье ээ.

Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Надаа 2 багц асуулт байна. Яг нөгөө журмын төслийн 2.2-той холбоотой, 2.5-тай холбоотой гэсэн үг.

2.2 дээр хүрэлцэн ирэх боломжгүй бол урьдчилан мэдэгдэнэ гээд. Тэгэхээр бид хэд манай Ёс зүй, дэгийн байнгын хорооны хувьд 2025 онд ялангуяа яг энэ нэг ийм энэ парламент төлөвлөгөөтэй явдаг. Хэд хоногийн өмнө мэдэгдэх юм. Тэр тухай Их Хурлын гишүүдэд чуулганд орохоос нь өмнө өнөөдөр энэ чуулганд энэ сайд оролцох юм байна, энэ сайд оролцохгүй юм байна энэ тэр гэдэг мэдээлэл ирдэг баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр яг нэг ийм мэдээллийн ил тод байдал төлөвлөх ийм боломжтой байдал 2-ыг манай Ёс зүй, дэгийн байнгын хороо энэ 2025 онд парламентад хэвшүүлмээр байна. Одоо жишээ нь нөгөө дараа 7 хоногийн хуваарь 5 дахь өдөр батлагдана гэдэг чинь ингээд хэн ч ямар ч ажлаа төлөвлөх боломжгүй ингээд яг 5 дахийг хүлээж байгаа байхгүй юу. Ингээд Их Хурал ийм

байхаар угаасаа Засгийн газрын ажил нь төлөвлөхгүй. Засгийн газар ийм байхаар яам нь ажлаа төлөвлөхгүй. Тэгээд би л яг ойлгож байгаа байхгүй юу. Ингээд нэг гэнэт гэнэт хуралтай гээд ингээд дуудаад байдаг байсныг чи яагаад ингээд гэнэт гэнэт гэж дуудаад байдаг юм ямар сонин юм бэ гэж бодоод байдаг байсан чинь ингээд яг манай Их Хурлын өөрийнх нь ингэж ажиллаж ирсэн арга барил. Тэгээд дээрээс нь яах вэ ойлгож байгаа. 4 дэх, 5 дахь өдөр чуулган болоод чуулганы дараа дараагийн зүйлүүдийг төлөвлөхөөс өөр аргагүй нөхцөл байдал орж байгааг ойлгож байгаа.

Тэгэхээр энийг хамгийн эвтэйхэн зөв боломжтой ямар хувилбар байх вэ? Энэ өөрчилж болох зүйл гэж би хувьдаа харж байна. Тэгэхээр манай Ёс зүй, дэгийн байнгын хорооноос энэ санаачилгыг гаргаасай гэдэг хүрээнд 2.2 дээр жишээ нь хурал даргалагчид, сайд ямар хугацааны өмнө мэдэгдэх ёстой юм. Тэгээд мэдэгдээгүй бол 72 цаг байх юм уу, 24 цаг байх юм уу гэдгийг манай ажлын хэсэг өөрөө судалж байгаад нэг зохистой хугацааг ямар ч байсан нэг хугацаа оруулъя, нэг.

Дараа нь хоёрдугаарт чуулганаас өмнө аль аль Засгийн газрын гишүүд оролцох юм. Аль аль нь оролцохгүй юм бэ гэдгийг чуулганаас өмнө гишүүдэд бас нэг хэдэн цагийн өмнө мэдэгдэх юм гэдэг энэ 2 заалтыг заавал оруулъя гэсэн саналтай байгаа. Тэгээд бид нар чинь нөгөө асуултаа бэлдэнэ гээд л. Ингээд л зөндөө олон бэлтгэлийг чуулган дээр хангаж байгаа учраас энэ байх ёстой болов уу гэж бодож байна.

2.5-тай холбоотой зүйл дээр журам бол хэм хэмжээ тогтоох ёсгүй, журам бол процессыг тогтоох ёстой гэдэг зарчмыг баримтлаад, 2.5-ын хувьд бол яг найруулгын хувьд бөгөөд заалтын хувьд жоохон засахгүй бол болохгүй байна гэдэг ийм саналтай байгаа. Тэгэхдээ энэ дээр жишээ нь ингэчихсэн байна л даа. Нөгөө асуулт нь юу вэ гэвэл хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргахгүй гэхээр нөгөө бусад салбарын асуудлаар жишээ нь Хууль зүйн яамны сайд бол эрүүл мэндийн салбартай холбоотой асуудал дээр зарчмын зөрүүтэй санал давхар гаргахгүй болж хязгаарлагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр асуулт яг ингээд нөгөө энэ эрхийг хязгаарлаж байгаа тохиолдолд нэг 5, 6 шалгуурыг хангасан байх ёстой байгаад байдаг. Тэгэхээр нөгөө зохистой байх ёстой, тэнцвэртэй байх ёстой гээд ингээд ийм зарчмууд байгаад байдаг.

Тэгэхээр яг энэ нөгөө нэг эрхийг хязгаарлаж байгаа тохиолдолд баримтлах энэ 6 нөгөө шалгуурыг хэрхэн.

Б.Баярбаатар: Ажлын хэсэг Ариунзаяа гишүүн хариулах уу?

А.Ариунзаяа: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Журмын 2.2 дугаар заалт нь өөрөө Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн заалтыг мөрдөж байгаа учраас тухайн заалтынхаа дагуу хугацаа хоног 2 хоногийн өмнө гэдэг билүү хугацаа хоног нь Дэгийн тухай хууль дээрээ байгаа тиймээ. 2 хоног гэж байгаа шиг санаж байна. Ямар ч байсан энэ 7 дугаар зүйлийн 7.3-д заасан шалтгаануудаараа урьдчилан мэдэгдэх үүрэг нь бас хуулиараа тогтоогоод өгчихсэн хугацаатай байдаг учраас тэр хугацааныхаа дагуу магадгүй энэ журам дээрээ нөхөөд оруулчхаж болно. Үүнийгээ бол бид нар дахиад нэг нягтлаад

хараадахъя. Хэрэвзээ байхгүй бол энэ саналыг бол ярилцаж болох байх гэдэг ийм саналтай байна.

Нөгөө нь болохлоор 2.5 дээр дахиад л нөгөө хэлэхэд Засгийн газрын гишүүний хувьд жишээлбэл та сая хэллээ аль салбарын сайд нь нөгөө салбарынхаа асуудал дээр зарчмын зөрүүтэй санал илэрхийлж болохгүй юу гэдэг ийм асуудлыг хэлж байна. Болно оо болно. Гагцхүү Засгийн газар дээрээ л тухайн хуулийг өргөн барихаас өмнө Засгийн газар дээр хэлэлцүүлж байх явцдаа энэ асуудлаа ярилцах ёстой. Энэ асуудлаа ярилцаад угаасаа тэр чинь зүгээр сайд өөрөө дангаараа сууж байгаад хийчихдэг асуудал биш байхгүй юу. Тухайн яамны бодлогын газрын бүхий л хүмүүс оролцоод яг энэ ирүүлж байгаа санал дээр манай яамнаас эрхэлж байгаа асуудал дээр ямар нөлөөллүүд үзүүлж байгаа юм энэ дээр ямар санал байх ёстой юм гэдгийг албан ёсоор хүргүүлдэг. Ингэж байж тухайн салбарын ирүүлж байгаа саналыг хэрхэн яаж харгалзах вэ гэдгийг хууль санаачлагч нь авч үзээд тэгээд дахиад Засгийн газрын хуралдаанууд дээрээ мэтгэлцээнээ өрнүүлээд тэгээд эцсийн байдлаар нэгдсэн байр сууриас энэ шийдвэрийг гаргадаг байхгүй юу. Тэгэхээр Засгийн газраас Засгийн газрынхаа хуулийнхаа дагуу нэгдсэн энэ шийдвэрийг гаргаад Улсын Их Хурлын чуулганаар өргөн бариад хэлэлцүүлэх болсон бол Засгийн газрын гишүүний хувьд Засгийн газрын аль нэг салбарын сайд нөгөө сайдынхаа оруулж ирж байгаа асуудал дээр дахин өөр санал илэрхийлэхгүй, хамтын шийдвэрээ дагаж явна гэсэн ийм л асуудал. Энэ нь бол эргээд дахиад хэлэхэд Засгийн газрын тухай хуулиараа, Улсын Их Хурлын хуулиараа зохицуулагдсан байгаа асуудлууд. Энэ нь ер нь яагаад энэ асуудлуудыг оруулаад байгаа юм бэ гэхлээр ердөөсөө л энэ хяналтын болон гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, энэ хоорондын харилцаа болон ер нь зарчмаа л зөв барьдаг байгаасай гэдэг энэ хяналт үүргийн тогтолцоог юу гэдэг юм дээ баталгаажуулж байгаа гэдэг юм уу журмаараа дахиад үүнийг оруулж ирж байгаа ийм асуудал. Ямар нэгэн байдлаар тэнгэрээс аваад оруулаад ирсэн заалт биш. Энэ бол хуулиараа болон одоог хүртэл мөрдөгдөж ирсэн энэ зарчмынхаа дагуу явж байгаа асуудал юм гэдгийг онцлон хэлье ээ.

Б.Баярбаатар: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Надад энэ журмыг уншаад энэ 3.2-той холбоотой яг хариуцлага тооцохтой холбоотой энэ заалт дээр нэг хэд хэдэн асууж тодруулах юм байна. Тэгэхээр энэ журамд заасан чуулганы хуралдаанд оролцох журмыг зөрчсөн гишүүнд хариуцлага тооцуулах саналаа Ёс зүй, дэгийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад албан бичгээр хүргүүлнэ гэсэн. Тэгэхээр энэ дээр өөрөөр хэлэх юм бол хуралдаа суугаагүй бол, үгүй бол юу гэдэг юм асуулт асуучихсан бол ч гэдэг юм уу асуулт асууж байхад суудлаасаа хариулаагүй бол ч гэдэг юм уу тиймээ. Яг тэр үед асуултад нь Засгийн газрын гишүүний хувьд асуултад хариулаагүй бол. Яах вэ энэ дээр бол байхгүй л байна л даа.

Тэгээд одоо дэмжсэн биш магадгүй эсэргүүцсэн өнгө аястай байр суурийг илэрхийлсэн бол энэ тохиолдолд хариуцлага тооцуулна гэсэн байна л даа. Тэгэхээр энэ дээр саяын энэ алдаанууд чинь өөр хоорондоо ингээд чанарын хувьд жаахан ялгаа зааг байх уу? Хэдэн удаа тасалбал ямар хариуцлага хүлээлгэх юм? Нэг удаа таслангуут л нь шууд хариуцлага хүлээлгэх юм уу? Хэдэн удаа тасалбал хариуцлага хүлээлгэх юм нэгдүгээрт.

Нэг удаа зарчмын зөрүүтэй саналаа илэрхийлчих юм бол ч гэдэг юм уу эсвэл эсрэг байр суурь илэрхийлчих юм бол энийг нь хэн бүртгээд хэн энэ асуудлыг гаргаж тавиад тэгээд одоо нөгөө хариуцлага тооцуулахаар асуудлыг цааш нь ингээд тавих юм бэ гээд ингээд яг энэ 3.2 дээр өшөө жаахан нэг тодруулах тийм юм байх уу, үгүй юу л гэж би тодруулж асуух гээд байна л даа. Нөгөө алдаанууд чинь хоорондоо жингийн хувьд, нөгөө ач холбогдлын хувьд тийм ялгаа заагтай байх уу? Нэг нэг удаа алдчихангуут л нь хуралд нэг удаа ирээгүй байхад л шууд хариуцлага тооцоод явчих юм уу яах юм? Энэ дээр би 3.2 дээр нэг жаахан яг цагаа болоод ирэхээр энэ чинь жаахан ерөнхий байгаад байна уу даа гэж би бодоод байх юм.

Б.Баярбаатар: Хариулах уу? Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Хэрлэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол журмаа аль болох ерөнхийлөн болон хууль зөрчихгүй байх үүднээс маш их тийм ерөнхий заалтуудыг оруулсан байгаа тиймээ? Яг энэ хариуцлага тооцохтой холбоотой Засгийн газрын гишүүнд хариуцлага тооцох нэг л субъект байгаа. Нэг л эрх нь бол Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайдад л байдаг. Тухайн Засгийн газрынхаа хуулийн дагуу болоод Засгийн газрын мөрдөж байгаа хууль тогтоомж, журмуудынх нь дагуу Ерөнхий сайд өөрөө тухайн хүндээ ямар хариуцлага хүлээлгэх вэ, ямар үед хариуцлага хүлээх вэ гэдэг нь бол Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал байгаа тиймээ. Бидний хувьд болохлоор ямар нэгэн байдлаар бүүр үнэхээрийн давтамжтайгаар үнэхээрийн Засгийн газрынхаа эсрэг байр суурийг тогтмол илэрхийлээд байгаа буюу нэг удаагийн асуудал бол тухайн асуудлаасаа хамаараад бид нар ярилцаж болно шүү дээ тиймээ. Бүр тогтмол ийм байгаа хүнийг бол яалт ч үгүй Ёс зүй, дэгийн байнгын хороогоор хэлэлцэж энэ хариуцлага тооцох талаар санал хүргүүлэх үү үгүй юү гэдэг хамтын шийдвэрийг бол гаргана.

Нөгөө талдаа бол Улсын Их Хурлын дэгийн тухай хууль болон Улсын Их Хурлын хуулиараа Улсын Их Хурлын гишүүн жилдээ ажлын 5 хоног шиг санаж байна тиймээ ажлын 5 хоног ажлаа тасалсан гэж үзэх юм бол хариуцлага тооцох талаар Ёс зүй, дэгийн байнгын хороогоороо авч хэлэлцэнэ гэсэн ийм хуулийн хязгаар заалтууд байгаа учраас түүнийхээ дагуу л бид нар энэхүү ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ гэсэн үг. Тухайлаад нэг удаа үг хэлсэн бол эсвэл нэг удаа тэгсэн бол тэдэн удаа тасалсан бол гэдгийг энэ журмаар зохицуулах нь бол өөрөө буруу юм гэдэг ийм хариултыг хэлье ээ.

Б.Баярбаатар: Тийм Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм гээд байгаа шүү дээ? Тийм ээ.

Энэ дээр 10.7 дахь заалт Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг Байнгын хорооны хуралд оруулах ба Байнгын хорооны хурлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна.

10.7.1 дээр Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.25-д заасан ХОМ-ийг бүрэн эрхийн хугацаанд зохих журмын дагуу 2 ба түүнээс дээш удаа үнэн зөв гаргаж өгөөгүй бол.

10.7.2 дээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18.1-д заасан хариуцлагыг хуралдаан даргалагчаас тухайн жил 3 ба түүнээс дээш удаа ноогдуулсан бол.

10.7.3 дээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулганы нэгдсэн, Байнгын, Дэд, Түр хорооны хуралдааныг тухайн жилд хуралдааны ирцэд бүртгүүлсэн дүнгээр хоцорсон буюу тасалсан цаг нь ажлын 5 өдрийн цагаас дээш гарсан бол гэдэг ийм үндэслэлээр манай Байнгын хороо хариуцлага тооцно. Засгийн газрын гишүүнд хариуцлага тооцох асуудлыг сая Ариунзаяа гишүүн тодорхой ярьчихаж байгаа.

Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын хуралдаануудад Засгийн газрын гишүүдийн оролцох журмыг хэлэлцэж байгаа асуудлыг би ер нь их зөв гэж бодож байгаа юм аа. Тэр тусмаа бид нар Улсын Их Хурлын тухай хуульд энэ асуудлыг Ёс зүй, дэгийн байнгын хороо зохицуулж өгнө өө л гэчихсэн тохиолдолд, ямар ч байсан Байнгын хороогоороо энэ журмаа хэлэлцэж байгаа нь зөв нэг талаасаа.

Нөгөө талаас сая Баярбаатар дарга ч ярилаа, Лодойсамбуу гишүүн ч ярилаа. Ер нь энэ хууль тайлбарлах асуудал тодорхой субъектэд олгогддог учраас бид өнөөдөр тэр хуулийг энэ хуулийг зөрчиж байна гэж ярьж байгаа нь бол жаахан зохимж муутай. Гэхдээ Их Хурлын гишүүний хувьд ингээд орчихвол тэнд зөрчил үүсэх юм биш биз, энд үүсэх юм биш биз гэж сануулж анхааруулж байгаа нь бол яах аргагүй чухал гэж ингэж бодож байгаа юм. Зүгээр гол асуудал юундаа яагаад бид нар Засгийн газрын гишүүд дээр анхаараад байна вэ гэхээр Засгийн газраас санаачилсан хууль тогтоомжийн хувьд Засгийн газар бол нэг л субъект болж ордог. Засгийн газрын гишүүн тэр асуудалд хэвийн энгийн журмаар явахад бол 14 хоногийн дотор саналаа боловсруулаад Засгийн газрын хуралдаандаа оруулаад саналаа нэгтгээд шийдвэрээ гаргаад Их Хуралд өргөн барьчихдаг. Энэ тохиолдолд Засгийн газрын гишүүн дахиад зарчмын өөр байр суурь илэрхийлэх эсвэл өөрөөсөө асуулт асуух бол угаасаа зохимжгүй. Ёс зүй талаасаа маш зохимжгүй юм байдаг. Сая бид нар үндсэндээ 3 удаа улсын төсөв хэлэлцлээ. Тэгээд тэрэн дээр хараад байхад манай зарим гишүүд их асуулт асуудаг, нэгдүгээрт. Тэр Засгийн газраас өргөн барьсан юман дээрээ, тэр засаг дээрээ зөндөө ярьчихсан юман дээрээ.

Хоёрдугаарт яг би Их Хурлын гишүүнийхээ хувьд гэж байгаад өөр байр суурь ялангуяа өнгөрсөн Их Хурал дээр их л олон хүн тэгдэг байсан л даа. Засгийн газраас өөр байр суурь гаргаад яриад байдаг. Кабинетын зарчим бол энд нь дандаа зөрчигдөөд байдаг. Тийм учраас энэ өөр байр суурь зарчмын зөрүүтэй санал Засгийн газраасаа өөр санал гаргах энэ тэрийг бол ингээд хязгаарлаж өгч байгаа энэ журмын заалтыг зөв гэж үзэж байгаа, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ журмыг нэгэнт л өнөөдрийн мөрдөж байгаа хууль тогтоомжийнхоо хүрээнд манай Байнгын хороо л гаргаж өгөх ёстой юм чинь бид нар аль болохоор зөрчил багатай энэ журмаа энэ хэмжээнд нь миний хувьд бол энэ оруулж байгаа үндсэндээ энэ чинь нэг 2 заалт л нэмж орж байна шүү дээ. Энэ заалтуудыг бол дэмжиж байгаа юм, дэмжиж байгаа. Ийм учраас журмаа энд энэ томьёолсон хэмжээнд нь ингээд батлаад мөрдүүлээд явчих.

Б.Баярбаатар: Ер нь санал хэлчихвүү Рэгдэл гишүүн. Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төсөлтэй холбоотой санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Ганмаа гишүүнээр тасаллаа. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн санал хэлнэ.

Ч.Лодойсамбуу: Ер нь л Монголын парламент Засгийн газар сүүлийн хэдэн жил энэ хэлэлцэхээс их зугтдаг болчихоод байгаа юм. Хэлэлцэхээс. Олон нийтээр хэлэлцүүлэхээс, өөрсдөө хоорондоо хэлэлцэхээс. Нөгөө улс төрөө даахгүй гэдэг нэг үгтэй. Тэгээд л хэлэлцүүлгээс аль болох хурдан яаж тойрох вэ гэдэг. Одоо кабинетын зарчим гээд яриад байгаа юм. Кабинетын зарчим гэдэг нь зөв ч бай буруу ч бай юу ч байсан санал нэг байхыг хэлж байгаа юм уу, эс үгүй бол кабинетаараа зөв шийдвэр гаргаад тэрийгээ дэмжээд явахыг хэлж байгаа юм уу. Одоо жишээлбэл энэ кабинетын зарчим гэдгийг л үндсэндээ тогтоох гэж Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Засгийн газрын тэргүүн нь өөрөө сайд нараа томилдог, өөрөө сайд нартаа хариуцлага тооцдог ийм болгосон Үндсэн хуулийн өөрчлөлтөөр.

Тэгэхээр одоо Ерөнхий сайд зарчмынхаа танхимын байр сууриас эсрэг байр суурь засгийн бодлогынхоо эсрэг явж байгаа бол тэр сайдтайгаа асуудал ярих эрх нь үүрэг нь Үндсэн хуулиараа Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайд байж байгаа. Тэгээд Ерөнхий сайдад байгаа энэ хариуцлагыг Ёс зүй, дэгийн байнгын хороо бид нар өөрсөд рүүгээ ингэж татаж оруулж ирэх ямар шаардлагатай байгаа юм. Үнэхээр зарчмын байр суурь өөр байр суурь илэрхийлээд байгаа бол тэр сайдтайгаа ярих үүрэг нь, эрх нь Үндсэн хуулиараа тэгэх гэж л энэ Үндсэн хуулийг өөрчилсөн шүү дээ. Одоо ингээд жишээлбэл түүрүүн Рэгдэл гишүүн хэлж байна. Төсвийн үеэр зарим Засгийн газрын гишүүд янз янзын асуулт гаргаад зарчмын зөрүүтэй санал гаргаад засгийн бодлогынхоо эсрэг юм шиг ингээд явсан гэж. Яагаад тэгж байгаа вэ яагаад тэгж байгаа гэвэл хэлэлцэхгүй байгаа байхгүй юу. Ярилцахгүй байгаа байхгүй юу. Засаг дээрээ тодорхой Засгийн газрын гишүүд нь ярихгүй байгаа.

Хоёр намын дарга нь шийдээд л ерөөсөө ингэж явна гээд л шийдчихдэг. Нөгөө сайд нарынхаа саналыг сонсохгүй байгаа байхгүй юу. Сонсохгүй байгаа бол сонсдог газраа хэлье л гэж байгаа шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол ерөөсөө хэлэлцэхгүй зөвшилцөхгүй байгаа. Энийг бид нар тойруулах нь өөрөө энэ хэлэлцэхгүй зөвшилцөхгүй зүгээр ингээд бяраад явдаг. Энийг бид нар дахиад нэг ийм алхам шатыг нэмэх нь бол бид нарт үнэхээр харамсалтай л алхам болно. Ер нь аливаа нэг жишиг, сайн муу жишиг тогтохоороо цаашаа тэр нь дадал болдог. Цаашаа ингээд хэвшээд явдаг. Одоо манай Их Хурлын гишүүд заримдаа бид нар ингээд нэг буруу зүйл бодоод байгаа. Бид нар Монгол Улсын сүүлийн парламентын гишүүд юм шиг, эс үгүй бол энэ удаагийн парламентын гишүүд өмнөхүүдээсээ хамгийн ухаантай юм шиг ингэж авирлаад байгаа. Одоо тэр гишүүдэд олгодог тэтгэмж дэмжлэгтэй холбоотой асуудлууд дээр байр суурь хэлж байгаа нь ч гэсэн. Бид нар өнөөдөр дараагийн парламент хэрхэн дархлаатай баталгаатай энэ төрийн ажлыг хийж явах вэ гэдгийг илүү сайн болгох нь бид нарын энэ цаг хугацааны үүрэг шүү дээ. Ерөөсөө л үе үеийн парламентын үүрэг. Гэтэл бид нар дараагийн парламентаа хэлэлцдэг зөвшилцдөг. Ер нь ингээд олуулаа хэлэлцвэл буруугүй бүлээн усаар угаавал хиргүй гэж. Энэ хэлэлцүүлгийг ингээд тойрдог ийм буруу жишгийг бид нар ингээд үлдээгээд дараа дараагийн парламент энэ чинь сүүлийн парламент биш шүү дээ. Тэгэхээр бид нар энэ тогтоож байгаа жишгээ сайн боддог байх хэрэгтэй. Ер нь хэлэлцэхээс зугтаадаг болсон нь үнэн шүү дээ. Одоо энэ бүх л юм, гол шийдвэрүүд, хуулиуд дандаа баярын өмнө гардаг. Том том баяруудын өмнө дандаа шөнө ингэж байж байгаад 2, 3 сар завсарлаад алга болдог. Тэгээд манайх

чинь улирлын шинж чанартай уламжлалт зан заншлын бас нэг нөлөөллүүд байна гээд ингээд ер нь ажил хийдэг, яг энэ олон нийтээр хэлэлцүүлдэг энэ цагийг тойрох шалтаг шалтгаанууд мунддаггүй. Тэгээд хэлэлцэхгүй болохоор хэлэлцэхээсээ айсандаа тэрийгээ ингээд бүүр дүрэм болгоод бүүр сүүлдээ суух нь л дээ. Энэ ковидоос хойш л нэг ийм болчхоод байгаа юм. Ерөөсөө юмыг нэг тойруулдаг, гялс л явуулдаг, олон нийтийн хэлэлцүүлэг энэ тэр хийлгэдэггүй, улс төрөө даахгүй гэдэг нэг үгтэй. Тэгээд энийг л хэдүүлээ дүрэмлэж, журамлаж, бүүр ингээд нэг буруу жишгийг шинээр дахин дахин нээж үүсгэмээргүй байгаа юм. Жоохон агуулгаар нь ингээд томоор нь хараад бид нар нэг парламентын гишүүн байна, парламентын гишүүд байна, тэгээд Ёс зүй, дэгийн байнгын хороо байна. Бид нар бас нэг энэ парламентынхаа бас нэгэн суурь зарчмуудыг хамгаалах талдаа байсан нь дээр байх аа.

Б.Баярбаатар: Санал хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би энэ нөгөө журмын төслийн 2.2-той холбоотой саналаа би зарчмын зөрүүтэй саналын томъёолол гэдгээр хугацаа бичээд өгчихлөө. 48-аас доошгүй цагийн өмнө хуралдаан зохион байгуулагчид мэдэгдээд тэгээд гишүүдэд бусад гишүүдэд гэж томъёоллоо тийм бусад гишүүдэд 24-өөс доошгүй цагийн өмнө хуралдаан зохион байгуулагчийн зүгээс энэ ирцийн талаар мэдээллийг хүргэнэ гээд ингээд оруулчихлаа.

2.5 дээр болохлоор хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргахгүй гэсэн мөртөө хэрэв санал гаргавал шаардлагатай гэж үзвэл гээд нөгөө хоорондоо ийм зөрчилтэй 2 заалт ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг зөв болгохгүй бол энэ чинь өөрөө бүр аягүй том нөгөө маргааны юу болох гээд байна? Тэгээд Засгийн газрын гишүүнээр уламжлан гээд одоо нөгөө бусад гишүүдээрээ уламжлан гэхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яг энэ 2.5-ыг л нэг жаахан найруулга зарчмын хувьд тэгээд жаахан нарийвчлах ийм л саналтай байна. Тэгээд нөгөө энэ чинь ганцхан чуулганы хуралдаан биш, Байнгын хороо, Дэд хороо, Хянан шалгах түр хороо, Бүлгийн хурал дээр оролцох зарчмыг бүгдийг нь ингээд энэ журмаар зохицуулах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө эсвэл чуулган, Байнгын хорооныхыг жоохон ялгамжтай байх ёстой юу, яах ёстой вэ гэдэг дээр.

2.5 дээр л жаахан эргэлзээд л байна даа.

Б.Баярбаатар: Очирбат гишүүн.

Г.Очирбат: Гишүүддээ бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Манай зарим гишүүд тэгээд яг өнөө өглөө сэрсэн юм шиг хандлагаар зарим юманд хандах юм. Энэ ажлын хэсэг чинь 2 сар ажиллаж байгаа. 2 сарын хугацаанд 2-оос 3 удаа санал авсан Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүдээс.

Тэгээд Ариунзаяа гишүүн бас ажлын хэсгийн ахлагч гишүүдээс хэчнээн санал ирсэн юм, яг хэн хэн өгсөн юм? Хэн хэн нь ямар саналыг нь оруулсан юм гэдэг талаар бас мэдээлэл өгчихвөл зүгээр байгаад байгаа байх. Тэгэхгүй яг өнөөдөр яг Байнгын хорооны хурал хуралдангуут өнөө өглөө уншаад тэндээс ийм асууж байгаа юм шиг ийм байдлаар явбал цаашаа ер нь манай энэ Байнгын хорооны энэ хурлууд их төвөгтэй байгаа юм шиг харагдчихлаа. Яагаад гэхээр манай гишүүд бол энэ 2 сарын хугацаанд асар их боломжууд байсан. Ажлын хэсгийн даргатай уулзах,

Байнгын хорооны даргатай уулзах. Ялангуяа энэ Их Хурлын тухай хуулийн 43.3 дугаар заалтыг үндэслэж явж байгаа энэ журмын төслийг шүүмжлэх, үгүйсгэх янз бүрийн байдал байсан. Тэгээд яг Байнгын хорооны хурал явж байх үед бол энэ саналууд нэгтгэгдээд, энэ нь орсон, энэ нь ороогүй, энэ дээр нь ийм асуулт байсан гэдэг юмнуудаа л яримаар байгаад байгаа юм.

Мэдээж энэ ажлын хэсэг чинь олон талаас нь асуудлыг харсан. Засгийн газар, Хэрэг эрхлэх газрын дарга гээд олон хүмүүс саналаа илэрхийлсэн. Манай Байнгын хорооны гишүүд ч гэсэн олон саналууд орж ирсэн. Зарим нэг саналуудыг бол ямар шалтгааны улмаас хасаагүй юм, ямар шалтгааны улмаас хассан юм гэдэг бас ийм юмнуудыг манай Ариунзаяа дарга тухайн үед хэлж ярьж байсан гэж би санаж байна.

Тэгэхээр энэ журмын төслөө ингээд нэг сайхан цааш нь олон талаас нь хэлэлцсэн гэдэг утгаараа батлаад явбал зүгээр байх гэж бодож байна. Тэгээд Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүддээ хандаж энэ журмын төсөл дээр 2 сар ажилласан байгаа. Олон талаас нь харсан байгаа, олон хүний саналыг оруулсан байгаа шүү. Тэгэхдээ яах вэ ажлын хэсэг чинь түрүүлээд саналуудыг та бүхнээсээ олон удаа авсан байхгүй юу. Баярлалаа.

Б.Баярбаатар: Ганмаа гишүүн саналаа татсан. Бичгээр өгье гэж хэлээд татсан байгаа.

Гишүүдийн саналуудыг ерөнхийдөө ойлголоо. Очирбат гишүүн зарчмын том саналыг сая хэлж байна. Ажлын хэсэг төлөөлж. Ер нь бол Засгийн газрын гишүүдээс саналуудыг аваад явсан. Өнөөдөр Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйл дээр Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга нь Засгийн газраас Ерөнхийлөгч, Улсын Их Хуралтай харилцах асуудлыг эрхэлдэг байж байгаа. Энэ саяын Баасанжаргал гишүүний гаргадаг юун дээр чинь Засгийн газрын гишүүний хэрвээ зарчмын зөрүүтэй санал гарвал энэ Хэрэг эрхлэхээрээ, сайдаараа дамжуулаад л гарга гэж эрхийг нь өгч байгаа байхгүй юу, нэгт.

Хоёрт, ер нь бид нар яах вэ юмыг, аливаа юмыг хэлэлцэхээс зугтаад байгаа зүйл энд байхгүй л дээ. Зүгээр л энэ кабинетын зарчим гэдэг зүйл энэ улс төрийн соёл, тодорхой түвшний сахилга батын асуудал энд хамаарч байгаа юм. Засгийн газар, Улсын Их Хурал 2-ын хоорондын харилцаа, хамаарлын асуудал, хяналтын асуудал өөрөө 1 дүгээр асуудал. Засгийн газар өөрөө дотооддоо Засгийн газрын эв нэгдлийн асуудал чухал асуудал. Тэгээд аливаа асуудал дээр хэн нэгэн улс төрч хувийн байр суурь байж болно, өөрийн байр суурь байж болно. Янз бүрийн шалтгаанаар популист үзэл баримтлал илэрхийлэх ийм тохиолдлууд өмнө нь гарч байсан юм аа. Энэнээс болоод Монголын Засгийн газарт ч тэр төрийн түвшинд явагдах ажлууд гацаж байсан саатаж байсан тохиолдлууд ч байдаг юм. Тэгээд бид нар энэ ажил явуулах үүднээс л энэ журмыг өнөөдөр оруулж ирж боловсруулж ажлын хэсэг танилцуулж байна гэж би ойлгож байгаа.

Тэгээд би дахин хэлье Улсын Их Хурлын тухай хуулиар олгогдсон үүргийг манай Байнгын хороо хүлээж байгаа. Ямар нэгэн байдлаар бид нар Засгийн газрын гишүүний эрхэд халдах Засгийн газрын гишүүний асуудлыг хумих тийм зүйлийг энэ журмаар төдийлөн хаагаагүй гэж ойлгож болох болов уу гэж бодож байна.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуудас дээр Баасанжаргал гишүүн 2 санал оруулж ирсэн байна.

2.2-т хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид урьдчилан 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ гэж нэмэх 48-аас доошгүй цагийн өмнө гэж нэмэх гэж оруулж ирж байна.

Энэ дээр ажлын хэсэг нэг санал хэлээч. Энэ дэгийн хуультай зөрчилдөж байна уу? Дэгийн хуулийг давсан барьсан иймэрхүү зүйлүүд харин гараад ирэх вий. Энийг нэг тайлбарлаач.

А.Ариунзаяа: Яах вэ бид хэлэлцэх асуудлыг баасан гараг бүр даргын дэргэдэх зөвлөл баталдаг, хэлэлцээд баталдаг. Яаралтай шуурхай асуудлууд ч гэсэн тухай бүрдээ гарахад даргын дэргэдэх зөвлөл шуурхай ээлжит бус хуралдаанаараа, хурал хэлэлцэх асуудлын тов, дараалал, хуралдааны одоо төлөвлөгөөг бол баталгаажуулж гаргадаг байгаа. Тэгэхээр эдгээр асуудлууд нь 48 цагаас доошгүй гээд журамлалчлахад өөрөө мөрдөгдөх боломжгүй ийм заалт ороод ирчих вий гэдэг ийм болгоомжлол бол байна аа. Ийм учраас яг энэ журам дээр хугацаа тавих нь бол буруу байх гэж бодож байна. Нөгөө талдаа бол зүгээр Баасанжаргал гишүүний хэлээд байгаа бид нар төлөвлөгөөтэй, ажлаа төлөвлөдөг байхын тулд тухайн хэлэлцэх асуудлууд нь хэд хоногийн өмнө мэдэгддэг байх, бэлтгэлээ хангадаг байх зарчмын энэ санал нь бол зөв өө. Гагцхүү яах вэ мэдээж улс орны эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай холбоотой цаг үеийн гэнэтийн шуурхай асуудлууд гардаг учраас нэн ялангуяа ковидын цаг үеэс хойш ер нь л ингээд байнгын тогтмол ийм нэг яарсан ийм нэг уур амьсгалтай, ийм нэг бэлтгэлтэй, ийм нэг шуурхай горимоор ажилласаар байгаад дадал болчихсон байна.

Тэгэхээр энийг бол эргээд төлөвлөгөөтэй явах ёстой гэдэг энэ саналыг бол зарчмын хувьд бол дэмжиж байна. Гагцхүү энэ журам дээрээ 48 цаг гэж зааж өгөх нь бол бас өөрөө эргээд мөрдөгдөхгүй байх ийм заалт болчих вий гэдэг ийм болгоомжлол байна аа.

Б.Баярбаатар: Хэрлэн гишүүнээс 3 санал орж ирсэн. Ганмаа гишүүн санал өгөх өгөхөөр байгаа юу? Одоо яах вэ микрофон дээр би хэлсэн шүү дээ. Та бичгээр өгье гээд түрүүн хэлчихсэн шүү дээ.

Тэгэхээр хурал даргалагчийн зүгээс би хурлыг 7 хоног хойшлуулах саналыг оруулж байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгье. Байнгын хорооны гишүүд саналаа нэгтгэж, тусгах саналуудаа оруулаад тэгээд хурлыг ирэх 7 хоногт дахин тов зарлаж хуралдуулъя гэсэн ийм саналыг оруулж байна.

Яах вэ тэгж болно. Тийм одоо жишээлбэл энэ дээр ингэх гээд байна л даа. Одоо ингээд саяын 2.2 дээр одоо жишээлбэл ингээд санал хураалт явуулаад яваад байж болно.

Хэдүүлээ санал хураалтаараа асуудлуудаа шийдээд шийдээд явъя тэгэх үү? 2.2 дээр Баасанжаргал гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ гэж нэмэх томъёоллыг.

Санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн оролцож 33.3 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

2.3 хуралдаан зохион байгуулагдсан бусад гишүүдэд гишүүн оролцох эсэх талаар мэдээллийг 24 цагаас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ гэж шинээр заалт нэмэх дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн оролцож 22.2 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Хэрлэн гишүүнээс гарсан санал байна.

Саналын томьёолол. Зарчмын зөрүүтэй санал биш саналын томьёолол гэж харж байна зөв үү?

1. Чуулганы хуралдаанд оролцох журам гэдэг томьёоллыг 2. чуулганы хуралдаанд оролцох гэж өөрчлөх редакцын саналаар авъя.

2. Энэ журам нь Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцох тухай зохицуулалт учраас 2.2 энд хамаарах уу? Байнгын, Дэд, Түр хороо, ажлын хэсгийн хуралдаанд оролцох тухай асуудал энд хамаарах уу? 2.2-ыг хасах саналтай байна гэсэн ийм.

Ариунзаяа гишүүн би 3 дахийг нь уншаадахъя. Та нэгдсэн байдлаар тайлбар өгчих үү?

3.2-т хариуцлага тооцуулах санал гэдэг нь субъектив нөлөөлөл үүсгэж болзошгүй тул илүү тодорхой болгож боловсруулах хэрэгтэй байна гэсэн ийм нарийвчлах юу л юм байна. Санал хураалгах боломжгүй саналууд байна эд нар.

Тэгэхдээ би энэ дээр тайлбар өгчихье Хэрлэн гишүүнээ. Одоо ер нь байна шүү дээ энэ хариуцлага тооцуулах санал гэдэг субъектив нөлөөлөл үүсгэж болзошгүй биш бид нар чинь ганцаараа шийддэг Байнгын хороо биш байхгүй юу. Улсын Их Хурлын байнгын хороо, Ёс зүй, дэгийн байнгын хороо. Өөрсдийн гэсэн хуультай, дүрэмтэй, дотоод ардчилалтай ийм Байнгын хороо. Хэн нэгэн Баярбаатар юм уу, хэн нэгэн Очирбат, Лодойсамбуу хариуцлага тооцуулах саналыг гаргах эрх байхгүй. Тэгэхээр хамтын шийдвэр гаргах учраас энэ ерөнхийлсөн зарчмаараа явах нь өөрөө зөв.

Энийг би бол тэгж ойлгож байна.

2.2-ыг хасах гээд байх шаардлага байхгүй болов уу? Ер нь тэгээд энэ журмаараа ингээд яваад мөрдөгдөх нь өөрөө зөв болов уу л гэсэн. Чуулганы нэгдсэн хуралдаан дотроо энэ чинь бүгд ороод явчхаж байгаа байхгүй юу. Одоо та түрүүн асуултаа асуучихсан хариултаа авчихсан. Ийм учраас ер нь бол байна шүү дээ түрүүн Очирбат гишүүн тодорхой хэлж байна шүү дээ.

2 сар энэ ажлын хэсэг ажилласан. Санал авахыг би 2, 3 удаа Вайбер групп дээр саналаа өгөөрэй гэж оруулж байгааг би харсан шүү нүдээрээ.

2.2-ыг хасах саналтай байна гэсэн саналыг Хэрлэн гишүүн оруулж байна. Хасъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 9 гишүүн оролцож 11.1 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Хэрлэн гишүүнийг дэмжсэнээр оруулъя.

Одоо Лодойсамбуу гишүүн горимын санал гаргана. Горимын саналаар санал хураалгана. 2.5-ыг чинь би түрүүн тайлбарлачихсан. Тайлбарлачихсан шүү зөрчилдөхгүй.

Хэрвээ зарчмын зөрүүтэй санал гаргах бол ЗГХЭГ-ынхаа даргаар дамжуулаад гаргах эрхийг нь бас үлдээж байгаа байхгүй юу. Бүр хааж болно, тэгэхдээ гаргахаар бол гэдэг зарчмыг нь нээлттэй орхиод тэгээд кабинетынхаа зарчмаар буюу Хэрэг эрхлэх газрын даргаараа дамжуулаад гарга. Тэгээд Засгийн газрын хуульд. Редакцын томъёолол засвар хийчих. Ер нь бол хуулиа барьж ажиллах юм бол Засгийн газрын тухай хуулиа барьж ажиллах юм бол Улсын Их Хуралтай харьцах албан тушаалтан бол Хэрэг эрхлэх газрын дарга шүү.

Лодойсамбуу гишүүн горимын саналаа гаргачих.

Ч.Лодойсамбуу: Энэ бол хэдүүлээ ингэж яаран батлаад явуулчих асуудал биш ээ. 2 сар ажлын хэсэг ажилласан байна гишүүдээсээ саналыг авсан юм байна аа. Би анхнаасаа энийг бол дэмжээгүй учраас дэмжээгүй байр сууриа Байнгын хороо анхны удаа хэлэлцэж байна өнөөдөр.

Тэгэхээр Байнгын хорооныхоо хуралдаан дээр хэлж байгаа. Ер нь бол энэ зөвхөн Засгийн газрын энэ удаагийн Засгийн газрын ажлуудыг явуулахын тулд нэгдсэн байр сууринд аваачаад тэгээд 1 ингээд зохион байгуулаад хурдан явъя гэдэг ийм тэрэн рүү нь оруулъя гэдэг ийм даалгавар авч байгаа. Тэгээд тэрнийхээ дагуу байгуулагдсан ажлын хэсэг ажлаа хийж байгаа гэдгийг ойлгож байна. Гэхдээ энэ өөрөө жишиг болж үлдэх нь том асуудал. Парламентын мэтгэлцээн, Засгийн газар хоорондын хэлэлцээр, энэ хэлэлцэх ярилцах бүхнийг зүгээр ингээд Ерөнхий сайд болон бусад том дарга нарт зүгээр дарга нар Ерөнхий сайдын засаглал руу л шууд аваачиж байгаад л энийг л түргэсгэж байгаа л асуудал. Тэндээс шийдсэн. Энүүгээрээ явна. Тэгээд парламентынх нь 20 гишүүн Засгийн газарт байж байдаг. Ингээд парламентаар хэлэлцүүлэх асуудал нь хүртэл битүү хатуу явдаг л ийм нөхцөл байдал руу л түлхэх гээд байна аа.

Тийм учраас горимын санал гаргаж байгаа юм. Энийг өшөө хойшлуулж бид нар сайн ярилцаж олон нийтээр хэлэлцүүлж бусад гишүүдээрээ ч гэсэн хэлэлцэж саналыг нь авах энэ зай хугацааг өгсөн нь дээр байх аа. Яагаад гэхээр олон нийт бол хэвлэл мэдээллийг хараад сууж байгаа. Тэгэхээр энийг бол хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байгаа юм.

Б.Баярбаатар: Хэдүүлээ юу яах вэ зүгээр санал хураалтаараа шийдээд явна. Байнгын хороо дотоод ардчиллаараа санал хураалтаар асуудлаа шийдээд явна.

Лодойсамбуу гишүүний горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн оролцож 33.3 хувиар горимын санал дэмжигдсэнгүй ээ.

Тогтоолын төслийг уншиж танилцуулна.

Ерөнхий сайд таслал, Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам.

Монгол Улсын үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасныг үндэслэн тогтоох нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх Улсын Их Хурлын гишүүний Улсын Их Хурлын чуулганы ажиллагаанд оролцох журмыг хавсралтаар баталсугай.

Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүй, дэгийн Байнгын хороо Б.Баярбаатарт үүрэг болгосугай.

Энэ тогтоолыг 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт саналтай гишүүд байна уу? Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Лодойсамбуу гишүүн асуулт санал нэг явчихъя.

Ч.Лодойсамбуу: Бид нар ингээд шийдвэрүүд гаргаад тэгээд араас нь дандаа нэг ийм шүүмжлэл дагуулсан. Одоо ингээд л Үндсэн хуулийн зөрчилтэй гээд л ингээд л заавал тэр шийдвэрийг нь гаргаж байж аан тийм байна гэх юм уу ер нь цаашдаа. Хууль тогтоогчид заавал хуульчид байх албагүй шүү дээ. Тэгээд байгаа байгаа зарчмын саналуудаа нэгтгээд ярилцах биш ингээд яараад хэлэлцээд баталчхаж байгаа нь жоохон харамсалтай байна. Энэ бол миний харж байгаагаар бол энэ асуудал дагуулна.

Монголын парламент ёсны зарчмын эсрэг л бид нар энэ шийдвэрүүд гаргаад байна шүү дээ. Бид нар тэгээд энэ Байнгын хороо уг нь энэ ёсыг хамгаалж байх л ёстой зарчмын байр суурь, тэр кабинетын зарчим, улс төрчийн ёс зүйн хувьд энэ кабинетаараа хэлэлцсэн асуудлуудад санал нэг байх ёстой ч гэдэг юм уу төрийн бодлого, тогтвортой явах ёстой ч гэдэг юм уу энэ зарчмуудтай санал нэг байгаа. Гэхдээ төрийн бодлого өөрөө сайн боловсруулж гарахад дотроо сайн хэлэлцдэг л байх ёстой, хэлэлцдэггүй болгоход дахиад нэг алхам хэдүүлээ нэмчихлээ дээ харамсалтай байна.

Б.Баярбаатар: Тогтоолын төсөлтэй холбоотой санал хэллээ.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

9 гишүүн санал хураалтад оролцоод 77.8 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүдэд баярлалаа. Өнөөдөр хэлэлцэх асуудал манай Байнгын хороо дотоод ардчилалтай ер нь цааш цаашдаа бид нар энэ асуудлууд дээр анхаарах ёстой. Саналуудаа сайн тусгаж байх ёстой. Манай бусад Байнгын хороодын гишүүд ч гэсэн аливаа асуудалд цаг тухайд нь их хариуцлагатай хандаж байхыг би

хуралдаан даргалагчийн үүднээс, Байнгын хорооны даргын үүднээс хүсье ээ.
Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

12.12 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА